



# Бодол, эргэцүүлэл, санал

## Онцлог ба онцгой нөхцөлд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах бодомж

“Хилийн хамгаалалтын онол, урлагийг хөгжүүлэх хөшүүрэг цагийн байдал дотор бий” гэсэн ЦШУ-ны дэд доктор, дэд профессор П.Дашийн бичсэн өгүүлэлтэй санал нийлэхийн зэрэгцээ хил хамгаалалтын онцлог ба онцгой нөхцөл, хувилбар бодомжуудаар санал бодлоо хуваалцахаар асуудал дэвшүүлж байна.

Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм /Хилийн суман, манаа/ 6-р бүлэг, “Онцлог нөхцөлд улсын хил хамгаалах”, Хил хамгаалалтын дүрэм /хилийн хороо/ 7-р бүлэг “Янз бүрийн нөхцөлд улсын хил хамгаалалтыг зохион байгуулахад харгалзах онцлог” гэдэгт гол нууртай хэсэг, ой намагтай хэсэг, уулархаг хэсэг, говь цөл хэсэг, хүйтний улирлын хил хамгаалалт, хилд ойрхон төмөр зам ба засмал зам өнгөрдөг хэсэг, хилийн шугамын ойролцоо ажил үйлдвэрлэл явагдаж байгаа болон төв суурин газар байрласан хэсэг, их хэсэгтэй хэсгийн хамгаалалт зэрэг нөхцөлүүд орж эдгээр хэсгүүдийн онцлог, хэсэг тус бүрд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах арга ажиллагааг тусгасан байдаг.

Олон улсын харилцаа, хилийн цагийн байдлын өрнөлт, өөрчлөлт, цаашдын төлвөөс дүгнэвэл дараахь онцлогуудыг зайлшгүй харгалзаж үзэн улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулах шинэ хувилбаруудыг онолын хувьд боловсруулж доорхи чиглэлүүдээр практик амьдралд туршин хэрэгжүүлэх нь алсыг харсан алхам болох буй заа.

**1. Улсын хилээр нэвтрэн ирсэн дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх үеийн хил хамгаалалтын онцлог.**

Өнөө үед дүрвэгсдийн асуудал дэлхий дахинд тэр тусмаа Азийн бүс нутаг хурцдаж байна. Одоогоор дэлхийд 22 сая дүрвэгсэд байгаагаас ОХУ-д л гэхэд 800.00 хүн эх орноосоо дүрвээд байгаа аж.

Хоёр гүрний дотоод улс төрийн байдал хурцадсанаас эдгээр орнуудаас мөн тэрчлэн гуравдагч орноос ялангуяа Хятадаар дамжин

хойд Солонгосоос дүрвэгсэд орж ирэх магадлал их байна.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг НҮБ-д 1951 онд баталсан бөгөөд энэ конвенцид дэлхийн 121 улс нэгдээд байна. Манай улс энэ конвенцид одоогоор нэгдээгүй байна. Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлалын 21-р зүйлийн 11-т "Хөрш орноос дүрвэгсэд олноор орж ирэх нь Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдалд эсрэг нөлөөлөх гадаад хүчин зүйл мөн" гэж заасан ба эндээс Монгол Улсад орж ирсэн дүрвэгсдийн асуудлыг яаж, ямар аргаар шийдвэрлэх, хүлээж авах юмуу? эсвэл улсын хилээр буцааж гаргах уу? гэсэн асуудал үүдэн гарч байгаа юм.

Улсын хилээр орж ирсэн дүрвэгсдийн асуудлыг хилийн бүс, зурваст шийдвэрлэхэд өөрөөр хэлбэл шийдвэрлэх эхний үе шатанд Хилийн Цэргийн үүрэг асар их байх болно.

## **2.Хилийн бүс, зурвас, хил орчим дахь эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалтын онцлог.**

Одоогоор дэлхийд эдийн засгийн чөлөөт бүс /ЭЗЧБ/ 157 ажиллаж байна. Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүсүүд бий болж ажиллах цаг тун ойртож байна. Манай улс Дэлхийн эдийн засгийн чөлөөт бүсийн холбоонд нэгэнт элсэн орсон билээ.

Алтанбулагийн ЭЗЧБ-д зориулж 500 га газар олгосон бөгөөд ЭЗЧБ-ийн хууль эрх зүйн актууд ойрын үед батлагдана. ЭЗЧБ-ийн ашиглалтын өмнөх захиргаа үйл ажиллагаагаа 1990-ээд оноос эхлэн хэрэгжүүлж байгаа үед үүргийнхээ хүрээнд ЭЗЧБ-д орох, гарах журам, хамгаалалтын онцлогийг харгалзсан хувилбаруудыг боловсруулах нь зүйтэй.

Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур, Түмэн голын төслийн хүрээнд дорнод чиглэлд эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдах нь ирээдүйн биш ойрын үеийн ажил болж байна.

## **3.Дархан цаазтай, тусгай хамгаалалттай газар бүхий хэсгийн хил хамгаалалтын онцлог.**

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар /ТХГ/ нутаг нь 20.5 сая га талбайтай бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 13.1 хувийг эзэлдэг. Үүнээс хилийн бүс, зурвас дахь ТХГ-ын нийт талбай 13191989 га, энэ нь нийт ТХГ-ын талбайн 64.3 хувь болж байна. Улсын хилийн бүс, зурваст Их говийн дархан цаазат газар, Хөх сэрхийн нуруу, Хан Хэнтий, Нөмрөг, Дорнод Монгол, Монгол дагуур, Увс нуурын ай сав, Говийн бага дархан цаазат газар, Хорьдол сарьдаг, Хөвсгөл, Говь гурван сайхан, Алтай таван богд зэрэг газар байдаг бөгөөд эдгээрийн хамгаалалтад 11 захиргаа, 1 салбар, нэлээд тооны байгаль хамгаалагч үүрэг гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалагч нар хариуцсан хэсгээ тодорхой хугацаанд бүхэлд нь эргэх, өдөр бүр эргүүл хийх, хяналт зохиох, чимээ чагнах, нэвтэрч буй хүмүүст зөвшөөрөл олгох, нутгийн иргэдийн дунд байгаль орчны хамгаалалтын талаар ухуулга сурталчилгаа хийх, иргэдийн мэдээллийг шалгах, отолт хийх зэргээр үүргээ гүйцэтгэдэг нь бидний зорилго, үүрэг нэг цэг, нэг шугаманд давхцаж байгааг оновчтой хамтын ажиллагаагаар шийдвэрлэснээр улсын хилийн хамгаалалт, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын нягтрал, үр дүн, харилцан ажиллагаа эрс сайжрах бололцоотой.

#### **4. Улсын хилийн бүс, зурваст байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин гарсан үеийн улсын хил хамгаалалтын онцлог.**

Улсын хилийн бүс, зурваст ойн ба хээрийн түймэр гарах /хил давж ирэх, хил давуулж алдах/ газар хөдлөлт, үер, цасан ба шороон шуурга болох, мөн хүн, малын гоц халдварт өвчин үүсэх зэргээр хилийн цагийн байдалд өөрчлөлт оруулсан үзэгдлүүд байнга гарч хүн, мал, эдийн засагт ихээхэн хохирол учруулсаар байгаа билээ.

#### **5. Хар тамхины ургамал ургадаг хэсгийн хил хамгаалалтын онцлог.**

Манай улс дэлхийн хамгийн их хар тамхи хэрэглэгч орон болох ОХУ, БНХАУ-тай хил залган, эдгээр орноор дамжин Европ руу хар тамхи орох гол зам дээр оршдог. Мөн хилийн бүс зурваст хар тамхи, мансууруулах бодисын түүхийн эд болдог ургамлууд элбэг ургадаг нь эдгээрийг түүх, бэлтгэх, хөрш улс руу зарж борлуулахаар гаргадаг нь хилийн зөрчил гаргах бодит нөхцөлийг бий болгож байна.

Хар тамхи хэрэглэгчид ОХУ-д 2.5 сая, Хятадад хагас сая илүү байдаг бөгөөд манай хилийн ойролцоо орших Өвөрмонголын Бугат хот нь Хятадад хар тамхины нууц үйлдвэрлэл хэрэглээгээрээ дээгүүрт ордог. Манай иргэд олноор амьдардаг зорчдог, шууд нислэг үйлддэг Казахстан улс нь Пакистан, Афганистан, Тажикстанаас ОХУ руу хар тамхи нэвтрүүлдэг гол газар болсон зэрэг нөхцөл байдлуудыг харгалзан үзэх ёстой. Сүүлийн үеийн хэвлэлийн мэдээнээс үзвэл хар тамхитай холбоотой хэргийн гаралт ихсэж Буянт-Ухаад Арабын Нэгдсэн Эмират улсын иргэнээс 400 гр кабанис бодис хураасан, Сэлэнгэ Дарханы оршин суугчид гараар боловсруулсан хар тамхийг ОХУ руу хил давуулан зардаг, хаанаас яаж оруулсан нь тодорхойгүй 400 гр кокаин бодисуудыг зарж борлуулж буйг мэдээлсээр байгаа нь улсын хилээр нууцаар оруулсан нь тодорхой.

Эдгээр хүчин зүйлүүдийг тооцон, онцлогт нь тохируулан хамгаалалтыг зохион байгуулснаар болзошгүй хохирлыг даван туулах, үйл ажиллагааны болон хамгаалалтын тасралтгүй байдлыг хангах юм.

Дээрх онцлог ба онцгой нөхцлүүдэд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах талаар сонсогчдоор дипломын ажил бичүүлж удирдаж байгаа бөгөөд судалгааны холбогдох материал, лавлах өгөгдөхүүн зэрэг нэлээд зүйлийг цуглуулсан тул сонирхож буй хүмүүс санал бодлоо солилцож болох юм.



Багш дэд хурандаа Ц.Ганболд.

### **ХИЛЧИН ШАЛГАГЧ ГЭЖ ХЭН БЭ?**

Улсын хилийн боомт газарт, төрийн өмнөөс зүтгэж яваа хянан шалгах үүрэг бүхий хилчнийг "шалгагч" гэдэг. Тэр нь дотроо шалгагч ахлагч, шалгагч офицер гээд бас ялгаатай. Үүрэг нь ч тусдаа. Нэг нь гүйцэтгэгч, нөгөө нь удирдагч.

Улсынхаа нэрийн өмнөөс ирсэн, буцсан зочин гийчидтэй нүүр тулан учирч хэн болохыг нь тодорхойлогч паспорт, баримт бичгийг шалгагчийн тухай олон зүйлийг ярьж болох юм.

Энэ удаа шалгагч-ахлагч ямар үүрэг гүйцэтгэдэг талаар товч өгүүлье. Шалгагч ахлагч нь төрийн албаны тухай хуулинд зааснаар төрийн тусгай албан хаагч гэдэг хэргэм зэрэгт багтдаг.

Хилийн цэргийн хил хамгаалах үйл ажиллагааны нэг хэлбэр болох Шалган нэвтрүүлэх алба /ШНА/ нь зорчигчийн хүчин төгөлдөр баримт бичгээр улсын хил нэвтрүүлэх, хил зөрчигч, зөрчихийг завдагсдыг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах гэсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ гэсэн хууль эрхийн үндэслэлээр шалгагч нар үүргээ биелүүлж, бас хариуцлага хүлээнэ.

Тийм ч учир шалгагч хүн сонор сэрэмжтэй, гярхай, албаны өндөр дадлагатай, сэргэлэн цовоо, бие бялдрын хөгжил сайтай, хэлний